

Өргөдөл, гомдол гаргах

1. Монгол Улсын иргэн дангаар буюу хамтарч төрийн байгууллага, албан тушаалтанд өргөдөл, гомдол гаргах эрхтэй

2. Өргөдөл, гомдлыг төрийн албан ёсны хэлээр бичгээр буюу амаар гаргана.

/Өргөдөл, гомдлыг цахим сүлжээгээр дамжуулан гаргаж болно/

3. Төрийн албан ёсны хэлийг мэдэхгүй бол төрөлх хэлээрээ өргөдөл, гомдол гаргаж болно.

Өргөдөл, гомдолд тавих шаардлага

1. Бичгээр гаргасан өргөдөл, гомдолд
 - овог, нэр
 - оршин суугаа газрын буюу шуудангийн хаягаа бичиж,
 - гарын үсгээ зурна.

/Хүндэтгэн үзэх шалтгаанаар гарын үсгээ зурж чадахгүй бол бусдаар төлөөлүүлэн зурж болно/

2. Өргөдөл, гомдлыг иргэд бичгээр хамтран гаргасан бол түүнд бүгд гарын үсэг зурах буюу эсхүл тэдгээрийн төлөөлөгч гарын үсэг зурж, төлөөлөх эрхээ нотлох баримт бичгийг хавсаргана